



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн Засаг даргын нэрэмжит  
цэрэг-спортын “Дөл-2026” цогцолбор  
тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3.3, 4.4.3.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2026” цогцолбор тэмцээнийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Чингэлтэй цогцолбор ОНӨТҮГ-ын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсугай.

2.Тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тэмцээний удирдамжийг хоёрдугаар, зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээнд оролцох дасгалжуулагч, тамирчдыг эрүүл мэндийн анхан шатны үзлэгээр оруулахыг Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг)-т, аюулгүй арга хэмжээг сахиулж, удирдлага арга зүйгээр ханган, сахилга, зохион байгуулалттай оролцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Б.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тэмцээний зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 06 -ны өдрийн... дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 105 ЖИЛИЙН ОЙГ  
ТОХИОЛДУУЛАН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДУНД  
ЗОХИОГДОХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ-  
2026” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Тэмцээний зорилго:

Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-  
эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа  
бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл,  
тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэхэд  
оршино.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад оролцогч байгууллага:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар
- Дүүргийн Биеийн тамир спортын хороо
- Дүүргийн Боловсролын хэлтэс
- Чингэлтэй нэгдсэн эмнэлэг
- Чингэлтэй цогцолбор ОНӨТҮГ
- Дүүргийн Улаан загалмайн хороо
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд

Гурав. Тэмцээн явуулах хугацаа, байрлал:

3.1. Цэрэг спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээн нь 3 үе шатаар зохион  
байгуулагдана. Сургуулиуд дотооддоо энэ удирдамжтай нийцүүлэн удирдамж  
боловсруулж, нэгдүгээр шатны тэмцээнийг сургууль дээрээ 2026 оны 03 дугаар  
сарын 18-ны өдрөөс өмнө зохион байгуулж шалгаруулна.

3.2. Сургуулиас шалгарсан тухайн тасгийн бэлтгэлийг хангаж, хоёрдугаар  
шатанд оролцуулна.

3.3. Дүүргээс шалгарсан тасаг нийслэлийн аварга шалгаруулах цэрэг-  
спортын “Дөл” тэмцээнд дүүргээ төлөөлөн оролцоно.

3.4. Тэмцээний үндсэн техникийн зөвлөгөөнийг 2026 оны 04 дүгээр сарын 02-  
ны өдөр 15.00 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион  
байгуулна. Нэгдүгээр шатны шалгаруулалт зохион байгуулсан илтгэх хуудас, 2-р  
шатанд оролцох сурагчдын мэдүүлэг, хувийн хэргийн хуулбар, сурагчдын сүүлийн 2  
сарын хугацаанд авхуулсан 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зураг, эрүүл мэндийн  
үзлэгийн хуудастай Цэргийн штабт бүртгүүлж мандат авна.

3.5. Хоёрдугаар шатны шалгаруулалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “Чингэлтэй цогцолбор” ОНӨТҮГ-ын байрлалд зохион байгуулж явуулна.

3.6. Хоёрдугаар шатанд тэргүүн байранд орсон тасгийг гуравдугаар шат буюу нийслэлийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын Дөл-2026 тэмцээнд оролцуулна.  
Дөрөв. Тэмцээний ерөнхий зохион байгуулалт:

4.1. Ерөнхий боловсролын сургуулиас тэмцээний нэгдүгээр шатанд шалгарсан тус бүр нэг тасаг, хоёрдугаар шатанд дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд (13 тасаг) оролцоно.

4.2. Тасаг нь Чингэлтэй дүүргийн харьяалал бүхий сургуульд суралцдаг 10, 11, 12 дугаар ангид суралцдаг 16-17 насны 11 (7 эрэгтэй, 4 эмэгтэй) сурагч гишүүнтэй байх бөгөөд нөөц эрэгтэй-1, эмэгтэй-1 гишүүнтэй байна. Насны доод хязгаарыг тус тэмцээний өдөр 15 нас 11 сар 31 хоногтой бол тухайн сурагчийг оролцуулахгүй байхаар тогтооно. Насны дээд хязгаарыг 17 настай байхаар тогтоож, тэмцээний өдөр 17 нас 11 сар 31 хоногтой бол оролцож болно.

Тасгийн бүрэлдэхүүн ижил өнгө, загварын дүрэмт хувцас, дүрэмт хувцасны загварт тохирсон хагас түрийтэй гутал, эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнхтэй байна.

#### Удирдлагын бүрэлдэхүүн-4

Сургуулийн захирал  
Нийгмийн ажилтан  
Биеийн тамирын багш  
Дасгалжуулагч Төрийн цэргийн байгууллагын  
(офицер, ахлагч)

#### Багийн гишүүд-13

Тасгийн захирагч-1  
Чиглүүлэгч-1  
Буудагч-8  
Буудагч эмнэлгийн зааварлагч-1  
Багын нөөц гишүүн-2

Дээрх 17 хүнд медаль олгогдоно. Мөн бэлтгэл, сургуулилтын үед дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд оролцох эмч, зөвлөх (бэлтгэл офицер, ахлагч), эцэг, эхийн төлөөлөл, туслах ажилтан байж болно. (медаль олгогдохгүй)

4.3. Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд (цаашид “Тэмцээнд” гэх) оролцох тасгийг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, биеийн тамирын багш, дасгалжуулагч нар хариуцан оролцуулах ба тасаг бүр дасгалжуулагч-багш /цэргийн цолтой офицер, ахлагч/-тай байж болно. Тасгийг Төрийн цэргийн байгууллагаас офицер, ахлагч дасгалжуулж оролцсон бол тэднийг тэмцээний шүүлт болон дотоод асуудалд оролцуулахыг хатуу хориглоно.

4.4. Тэмцээнд оролцуулах, бэлтгэлийг хангах тухай сургуулийн захирлын тушаал гаргаж албан тушаалтнуудыг томилгоожуулсан байна. Тасгийн

бүрэлдэхүүнийг Чингэлтэй нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, Ерөнхий эмчийн дүгнэлт гаргуулсан байх бөгөөд гишүүн бүр гэнэтийн ослын даатгалд заавал хамруулах ажлыг сургуулийн удирдлага, эмч, сахилга зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдлыг биеийн тамирын багш, дасгалжуулагч нар тус тус хариуцах, тамирчдын бичиг баримтын бүрдэл, бэлтгэл сургуулилтын явц байдлыг сургуулийн удирдлага, эцэг эхийн төлөөлөл хариуцан ажиллана. Тэмцээний явцад томилогдсон эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнууд тэмцээнд оролцогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавина. (шаардлагатай бол эцэг, эх, сургуулийн удирдлага, сурагчид гэсэн гурвалсан гэрээ байгуулна)

4.5. Тасгийн гишүүд уриа, логотой байж болно. Өөрийн багийн онцлогийг тусгасан 8 см голч бүхий ялгах тэмдгийг зүүн энгэртээ зүүсэн байна. Тасгийн чиглүүлэгч нь 40x40 см-ийн хэмжээтэй тасгийнхаа онцлогийг илэрхийлсэн дарцагтай байна.

4.6. Тасаг бүр сургуулийн туг, далбаатайгаар тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд зохион байгуулалттай оролцоно. Туг, далбааны хэмжээ 2.0x1.0 метрийн хэмжээтэй байна.

4.7. Тэмцээн болох байрлалд тамирчдыг хүрэлцэн ирэх, буцах унаа, тээвэрлэлт, хооллолт болон холбогдох бусад зардлыг тухайн сургууль, тэмцээний явцын болон шагнал урамшууллын зардлыг дүүргийн Засаг даргын Тамгын газар тус тус хариуцна.

4.8. Тэмцээний бэлтгэл хангах, сурагчдын гэртээ ирэх, буцах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах ажлыг тухайн сургуулийн удирдлага хариуцаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

Тав.Цэрэг спортын цогцолбор “Дөл” тэмцээний төрөл:

1. Гранат шидэх,
2. Жагсаалч тасаг шалгаруулах,
3. Гардан тулааны үзүүлэх тоглолт
4. Цэргийн 16 тоот (1,2,3 дугаар дасгал)
5. Эмнэлгийн анхны тусламжийн норматив,
6. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн норматив
7. Тасгийн захирагч нарын дундах тэмцээн
8. Гэрийн даалгавар
9. Буухиа


Зургаа. Тэмцээнийг дүгнэх журам:

Тэмцээний явцыг 1-5 онооны системээр дүгнэн хамгийн их оноо авсан байдлаар нь жагсааж байр эзлүүлэн дүгнэнэ.

Тэмцээний төрөл тус бүр дээр шүүгчээр ажиллаж байгаа ахлах шүүгчээс дүнг тухай бүр нь авч нийт багш, дасгалжуулагч, тамирчдад ил тод харагдах газар онооны самбар байрлуулж тэмцээний турш мэдээллийг танилцуулж байна.

---oOo---

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 26-ны өдрийн... дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт



## ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ-2026” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

Дүүргийн Засаг даргын нэрэмжит дүүргийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг явуулахад дараах дасгал, нормативуудыг хийж гүйцэтгэнэ.

### Нэг. Гранат шидэх:

Гранатыг бэлтгэсэн тойрогт шиднэ. 600 граммын жинтэй Ф1 гранатыг эмэгтэй 20 метр, эрэгтэй 30 метрээс тус бүр 2 ширхэг гранатыг 1, 3, 5 онооны тойрогт шиднэ. Энэ нь туршилтын 1, шалгалтын 2 гранат байна.

Гранатыг 1 метрийн диаметртэй тойрогт оновол 1 минут, 3 метрийн тойрогт оновол 40 секунд, 5 метрийн тойрогт оновол 20 секундийн шагнал өгнө. Тойргийн гадна шидсэн гранат тус бүрд 40 секундийн торгууль онооно.

### Хоёр. Жагсаалын үзүүлэх тоглолт:

Жагсаалын үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-8 минут байна. Жагсаалтын үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана.

1. Зэвсэгтэй, зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн,
2. Ёсолж хүндэтгэх, жагсаалаас гарах, жагсаалд орох, захирагч /дарга/-д очих, илтгэх, буцах ажиллагаа,
3. Тасгийн жагсаалын жигдрэлт:
4. Жагсаал удирдах дохио,
5. Жагсаалын дуу.

-Цэргийн жагсаалын дууг тасгийн захирагчийн сугалсан сугалаагаар шийднэ.

- |                                |   |
|--------------------------------|---|
| 1. Манай цэргийн жавхаа.       | Хөгжмийг Ш.Гун-Аажав, Шүлгийг Б.Жалбуу    |
| 2. Монгол Улсын төлөө зүтгэе.  | Хөгжмийг Б.Нямдорж, Шүлгийг Г.Пүрэвдорж   |
| 3. Энхийн үйлсэд монгол цэрэг. | Хөгжмийг Т.Насанбуян, Шүлгийг Г.Баатарнум |
| 4. Түүхт хил.                  | Хөгжмийг Л.Мөрдорж, Шүлгийг З.Пунцаг      |
| 5. Цэрэг хүний жавхаа.         | Хөгжмийг Г.Тэрбиш, Шүлгийг Ш.Сүрэнжав     |
| 6. Алхаад марш.                | Хөгжмийг Р.Ганбат, Шүлгийг Б.Доржпалам    |

зэрэг дуунуудыг жагсаалаар явах үедээ дуулна.

Эдгээр дуунуудыг тэмцээнд орохоос өмнө тасгийн бүх бүрэлдэхүүн сурсан байвал зохино.

Багууд жагсаалын үзүүлэх тоглолтын дүгнэх үзүүлэлтэд заагдсан жагсаалын ажиллагаа, хөдөлгөөнийг багтаасан үзүүлэх тоглолтыг “Цэргийн жагсаалын дүрэм”-ийн дагуу бэлтгэж үзүүлнэ.

Хугацааг ахлах шүүгчийн “Эхэл” командаар эхлүүлж, салаа, тасгийн захирагчийн дууссан тухай илтгэл өгснөөр дуусгана.

Жагсаалын үзүүлэх тоглолтыг дараах үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

№	Заавал гүйцэтгэх жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн	Үнэлгээ
<b>Зэвсэгтэй болон зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн</b>		
1	Жагсаалын үндсэн зогсолт	3 оноо
2	Байран дээрх болон явдал дунд эргэх хөдөлгөөн	3 оноо
4	Туг дарцаг эсвэл зэвсэгтэй ажиллагааг хийж гүйцэтгэх	4 оноо
	<b>Нийт</b>	10 оноо
<b>Ёслох, жагсаалаас гарах, орох, захирагч (дарга)-д очих, буцах ажиллагаа</b>		
1	Байран дээрээ болон хөдөлгөөн дунд ёсолж, хүндлэх	4 оноо
2	Жагсаалаас гарах, орох	3 оноо
3	Захирагч (дарга)-д очих болон буцах	3 оноо
	<b>Нийт</b>	10 оноо
<b>Жагсаалын дуу</b>		
1	Жигдрэлт	3 оноо
2	Дууг сурсан байдал	3 оноо
	<b>Нийт</b>	6 оноо
<b>Тасгийн жигдрэлт</b>		
1	Жагсаалын үзүүлэх тоглолтын зохиомж	3 оноо
2	Тасгийн жигдрэлт, жагсаалч байдал, гүйцэтгэл	4 оноо
3	Тасгийн захирагчийн жагсаал удирдах чадвар	3 оноо
	<b>Нийт</b>	10 оноо
<b>Жагсаалын үзүүлэх тоглолтын нийлбэр оноо</b>		36 оноо

Жагсаалын ажиллагаа, хөдөлгөөнийг буруу хийх, зөрөх, дүрмийн бус харьцаа гаргасан зөрчлүүдийг үнэлгээ бууруулах алдаанд тооцож, алдаа тус бүрд 10 секундийн торгууль өгнө.

Үзүүлэх тоглолтын хугацааг хэтэрсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн секунд бүрийг торгуульд тооцно.

Жагсаалын үзүүлэх тоглолтын эцсийн үнэлгээг тооцохдоо 4 үзүүлэлтээр авсан нийлбэр оноог таблицад (хавсралт 1) оруулан тохирох хугацаанд шилжүүлж, түүнээс багийн нийт авсан торгуулийг хасаж тооцох журмаар дүгнэнэ. Үзүүлэх тоглолтын нийт 36 оноо 6 минутын шагнал болно.

#### **Гурав.Гардан тулааны үзүүлэх тоглолт:**

Тасгууд гардан тулааны ажиллагааг харуулсан 8 минутын үзүүлэх тоглолтыг бэлтгэж үзүүлнэ. Гардан тулааны үзүүлэх тоглолтыг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

№	Заавал гүйцэтгэх дасгал, хөдөлгөөн	Үнэлгээ
---	------------------------------------	---------

1	Зэвсэгтэй ажиллагаа (ката)	6 оноо
2	Зэвсэггүй ажиллагаа (ката)	6 оноо
3	Хутган жадтай үзүүлбэр	6 оноо
4	Бие бүрэлдэхүүний сургагдсан байдал	6 оноо
	<b>Нийт</b>	24 оноо

Үзүүлэх тоглолтын үед гэмтэл, бэртэл авах, алдаа гарсан үйлдэл бүрд 10 секундйн торгууль, үзүүлэх тоглолтын хугацаа хэтэрсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн секунд бүрийг торгуульд тооцно.

Гардан тулааны үзүүлэх тоглолтыг 4 үзүүлэлтийн нийлбэр нийт 24 оноо 4 минутын шагнал болно.

### **Дөрөв.Цэргийн 1, 2, 3 дугаар 16 тоот гимнастик:**

Тасгийн бүрэлдэхүүн цэргийн 1, 2, 3 дугаар 16 тоот гимнастикийн дасгалыг тус бүр 1 удаа бөмбөрийн цохилтоор гүйцэтгэнэ. Алдаа гаргасан тохиолдол бүрийг 10 секундйн торгууль өгнө. (хувцас жигд байна)

### **Тав.Эмнэлгийн анхны тусламжийн норматив:**


Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх тэмцээнд баг тус бүрээс эрэгтэй 1, эмэгтэй 3 сурагч оролцоно. Оролцох бүрэлдэхүүн улаан загалмай нийгэмлэгийн таних тэмдэгтэй, эмнэлгийн анхны тусламжийн материал бүхий цүнхтэй байна. 4 сурагчдын нэг нь өвчтөн (эрэгтэй) болж хүн эмнэлгийн 3 дугаар норматив (цус тогтоох), 4 дүгээр норматив (үе мөчний хугаралд чиг тавих), 7 дугаар норматив (боолт хийх) эхний багын ахлагчийн сугалсан нормативыг бусад бүх баг хийж гүйцэтгэнэ. Шархтанд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, татан гаргах үед гаргасан нормативд заагдсан алдаа тус бүрд 30 секундйн торгууль өгнө.

### **Зургаа.Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн норматив №3а**

#### **“Цув, оймс, бээлий, өмс, газы” командаар:**

- Малгайгаа авч, бугаа юм түшүүлж тавиад, цамцны хормойг өмдний дотуур хийнэ;
- Хамгаалалтын оймс өмсөж, оосрыг өмдний тэлээнээс уях;
- Цувны ханцуйг өмсөж, үзүүрийг нь гадагш эргүүлэх;
- Газ эсэргүүцэгчээ өмсөж, малгайгаа дараа нь цувны юүдэнг өмсөөд, орой дээрх бүчээр нь хэмжээг тохируулна;
- Цувны товчийг товчлохдоо, холбох хоолойг дээрээсээ 2, 3 дахь товчны хоорондуур гаргах;
- Хамгаалах бээлийг өмсөж, ханцуйны үзүүрийн эргүүлгийг бээлийний дээгүүр буулгана.

Үнэлгээ	Үнэлгээ (минутаар)			
	Онц	Сайн	Дунд	0 оноо авбал

Хугацаа	4мин	4мин 20сек	5мин	5мин дээш	
Оноо	5 оноо	4 оноо	2 оноо	0 оноо	
Шагнал, торгууль	3мин шагнал	2мин шагнал	1мин шагнал	1 мин торгууль	

Оймсны гадна талын бүчийг товчлоостой байхад нь өмссөн. Цувны товчийг буруу товчилсон, төмөр түгжээгээр товчлоогүй, оймсны бүчийг дутуу товчилсон тохиолдол бүр 10сек торгуультай. Нормативыг багаар хийж гүйцэтгэнэ багийн хамгийн сүүлийн хүнээр цаг барина.

### Долоо.Тасгийн захирагч нарын тэмцээн:

Тасгийн захирагч нар Галын бэлтгэлийн 12 дугаар норматив (автоматын хагас задаргаа), 13 дугаар норматив (зэвсгийг угсрах), 15 дугаар норматив (магазин сумлах)-ыг биелүүлнэ.

Сугалааны дарааллаар эхний тасгийн захирагч 12, 13, 15 дугаар нормативаас сугалж бусад тасгийн захирагч нар сугалсан нормативыг дарааллын дагуу бүрэн хийж гүйцэтгэнэ.

Хугацаа	Үнэлгээ (минутаар)			
	Онц	Сайн	Дунд	0 оноо авбал
12 дугаар норматив	12сек	14сек	17сек	1 мин торгууль
13 дугаар норматив	22сек	25сек	30сек	
15 дугаар норматив магазин сумлах	30сек	35сек	40сек	
Шагнал, торгууль	1мин	40сек	20сек	

### Найм.Гэрийн даалгавар

Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2026” тэмцээний онцлогийг тусгасан, эх оронч сэдэвтэй контент бүтээх ба уг бүтээлийг фейсбүүк, цахим орчинд байрлуулж, [Чингэлтэй дүүрэг / Chingeltei District](#) фейж хуудсанд хандалт өгч байршуулна.

№	Үнэлгээ	5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо	шагнал
1	Агуулга, сэдэв	3мин	2м40с	2м20с	2мин	1 мин	3мин
2	Иргэдийн үзэлтийн тоо	х	х	1мин	40сек	20 сек	1мин
3	Лайк	х	х	х	30 сек	10 сек	30 сек

4	Шейр	х	х	х	30 сек	10 сек	30 сек
	<b>Нийт</b>						5 мин

(Тухайн контент нь 2-3 минутаас хэтрэхгүй байна)

### **Ес. “Буухиа тэмцээн”**

Багуудын хурд, хүч, авхаалж самбаа, гар нийлэмжтэй ажиллагаа, тэсвэр хатуужлыг сорих зорилгоор 400м урттай тойрогт, 4 цэг дээр өгөгдсөн дасгалыг гүйцэтгэнэ. Буухиа тэмцээнийг даалгавар гүйцэтгэсэн хугацаагаа, цэгүүдэд авсан оноогоор дүгнэнэ. Буухиа гүйлтийн нийт урт 600м байна.

#### **I цэг: Усанд осолдогчийг аврах цэг.**

Гараанаас гарч 100 метр замыг туулан I цэгт ирнэ.

Тусгайлан бэлтгэсэн талбайд тасгийн гишүүн бүр аврах цагариг /хөөсөн цагариг /шидэн усанд осолдогчийг аварна. Эргээс цагаригийн захын тойрог хүртэл 10метр зайтай байна.

- Цагаригийг 2 метр радиустай тойрогт оруулбал 3 минутын шагнал
- Цагаригийг 4 метр радиустай тойрогт оруулбал 2 минутын шагнал
- Цагаригийг г 6 метр радиустай тойрогт оруулбал 1 минутын шагналын оноо өгнө.
- Цагариг тойрогт ороогүй тохиолдолд 0 оноо.

#### **II цэг: Авхаалж самбааны цэг.**

Тасаг I цэгээс гарч, торон саад болон самбарыг давж, II цэгт ирнэ.

Тасгийн гишүүн бүр дүүжин савлуурт зургаа дарах, дүүжлэгдсэн байдлаас хөлөө өргөн савлуурт хүргэх, ес дарах цогцолбор дасгалыг гүйцэтгэнэ. Нэг цогцолбор дасгалд 1 минутын шагналын оноо өгнө. Гишүүн бүр өөрийн боломжоор энэ дасгалыг хийх бөгөөд эмэгтэй гишүүд хүч тамирын дасгалыг хийхгүй байж болно.

Шүүгч цогцолбор дасгалыг бүрэн, цэвэр гүйцэтгэснээр тооцох бөгөөд дутуу хийсэн тохиолдолд цогцолбор дасгалыг тооцохгүй. Тасгийн бүх гишүүдийн нийлбэрийг гаргаж багийн оноонд оруулна.

#### **III шат: Гал унтраах цэг.**

Тасгийн гишүүд II цэгээс гарч, 100 м замыг туулан III цэгт ирнэ. Тасгийн бүх гишүүд зориулалтын гал унтраах багажийг/ РЛО/ үүрэн 20м замыг туулж, саадыг тойрон галын дөлний хэлбэрт байг РЛО ус шүршигч ашиглан 2 минутын хугацаанд унагана.

Унагасан бай бүрийн тоогоор 1 минутын шагнал өгнө.

#### **IV цэг: Хүч тамирын цэг.**

Тасгийн гишүүд III цэгээс гарч 100 м замыг туулан IV цэгт ирнэ. Тасгийн бүх гишүүд 16кг-ийн туухайг өргөнө. Эрэгтэй гишүүн бүр-16, эмэгтэй гишүүн бүр-10 удаа өргөнө.

Шүүгч дасгалыг бүрэн, цэвэр гүйцэтгэснээр тооцох бөгөөд дутуу хийсэн тохиолдолд дасгалыг тооцохгүй. Тасгийн бүх гишүүдийн нийлбэрийг гаргаж багийн оноонд оруулна.

Тасаг IV цэгээс зам дахь саадыг давж, 200 метр замыг туулан барианд орно.

**АРАВ: ДҮН ГАРГАХ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ**

10.1 Тэмцээний дүнг гаргахдаа тасгийн гүйлтийн цэвэр цагаас шагналын хугацааг хасаж, торгуулийн хугацааг нэмэх журмаар хамгийн бага цагаар байр эзлүүлнэ.

10.2 Шагналт (I, II, III) болон тусгай (IV, V) байр, шилдэг 5 төрлөөр тэргүүлэгч тасгуудыг шалгаруулж, дараах шагнал, урамшуулал олгоно. Үүнд:

10.2.1 Тэргүүн байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Засаг даргын нэрэмжит шилжин явах цом”, “Алтан медаль”, “Өргөмжлөл”, 2,000,000 төгрөгийн мөнгөн шагналаар;

10.2.2 Дэд байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Мөнгөн медаль”, “Өргөмжлөл”, 1,500,000 төгрөгийн мөнгөн шагналаар;

10.2.3 Гутгаар байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Хүрэл медаль”, “Өргөмжлөл”, 1,000,000 төгрөгийн мөнгөн шагналаар;

10.2.4 Тусгай байр эзэлсэн 2 тасгийн бүрэлдэхүүнийг тус бүр “Өргөмжлөл”, 500,000 төгрөгийн мөнгөн шагналаар;

10.2.5 Шилдэг тасгийн захирагчийг “Цом”, “Өргөмжлөл”, 500,000 төгрөгийн мөнгөн шагналаар;

10.2.6 Шилдэг 5 төрлөөр шалгарсан 5 тасгийн бүрэлдэхүүнийг тус бүр “Өргөмжлөл”, 200,000 төгрөгийн мөнгөн шагналаар тус тус шагнаж, урамшуулна.